

ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

‘Боловсролын зээлийн сан’- гийн санхүүгийн
үйл ажиллагаанд хийсэн шалгалтын
тухай

Нэг. ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Сангийн Сайдын баталсан удирдамжийн дагуу БСШУЯ-ны харьяа Боловсролын зээлийн сангийн 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Боловсролын тухай, “Засгийн газрын тусгай сангийн тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Нийгмийн даатгалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, журам, дүрэм, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдлыг үндсэн баримт, материалд тулгуурлан хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг засч арилгуулах, давтан гаргахгүй байх арга замыг тодорхойлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө зааварчлага өгөхөд чиглэгдлээ.

Хоёр. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

БСШУСЯ-ны “Боловсролын зээлийн сан” нь 1993 онд “Сургалтын төрийн сан” нэртэйгээр төрийн бодлого, шийдвэр, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд дотоод, гадаадын их дээд сургуулиудад суралцаж буй оюутан, залуучуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, үндэсний болон урамшууллын тэтгэлэг, зээл болон буцалтгүй тусламж, замын зардлыг олгох үйлчилгээг зохион байгуулж ажиллаж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.13, 6 дугаар зүйлийн 6.4.6, 16 дугаар зүйлийн 16.4, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 9.3 дахь заалтыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2016 оны А/78/351 дүгээр тушаалаар “Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаарыг 23 байхаар тогтоож, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, сангийн дүрмийг шинэчлэн баталжээ. Боловсролын зээлийн сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл

олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулан, хэрэгжүүлэх зорилгын хүрээнд ажиллахаар тодорхойлжээ.

Тус сан нь үндсэн 3 үйлчилгээг эрхлэн зохион байгуулан ажилладаг байна. Үүнд:

А. Зорилтот хөтөлбөр

Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгодог сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг, тэтгэмж олгохтой холбоотой үйл ажиллагаа хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй байна. Үүнд:

1. Монгол Улсын “Боловсролын тухай хууль”, “Тусгай сангийн тухай хууль”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль”-ийн хүрээнд холбогдох тогтоол, журмын хэрэгжилтийг хангах, төрөөс үзүүлж буй тусламж, үйлчилгээг шаардлагатай иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, шинээр гарсан тогтоол, журмыг ард иргэдэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;

2. Ард иргэдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан төрийн үйлчилгээг бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол улсын Засгийн газрын тогтоолоор баталсан журмуудыг боловсронгуй болгох төсөл, гэрээний загварыг боловсруулахад санал оруулж ажиллах;

3. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдын шилжилт хөдөлгөөний бүртгэлийг Боловсролын зээлийн сангийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн төгсөгчдийн зээлийн эргэн төлөлтийг зохион байгуулж төлүүлэх;

Б. Дотоод зээл

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Оюутны хөгжлийн зээл” олгох тухай шинэ журмыг иргэдэд танилцуулах, хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн үүрэгтэй.

1.Оюутны сурах бололцоо, сургалтын чанар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, сургууль, банк, оюутныг холбож зохицуулж ажиллах;

2.Зээлийг иргэдэд чирэгдэлгүй олгохын зэрэгцээ, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, эрсдлийг бууруулах;

В. Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 217-р тогтоол, 2012 оны 19-р тогтоол, 2013 оны 271-р тогтоолуудын дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна. Үүнд:

1.Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын зэргийн сургалтад суралцахаар сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг

Боловсролын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталгаажуулж сургалтын төлбөрийн зээл олгох гэрээ байгуулах;

2. Гэрээний биелэлтэд тулгуурлан жил бүрийн санхүүжилтийг зохион байгуулах;

3. Гадаад зээлээр суралцаж төгссөн иргэдийн бүртгэл, зээлийн эргэн төлөлт, чөлөөлөлтийг зохих журмын дагуу зохион байгуулан ажиллах.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2016 оны А/78/351 дүгээр тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/99 тоот, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Боловсролын зээлийн сангийн захирлын 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 09 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн бүтцийг 23 орон тоотой баталсан байна. Үүнд:



Гурав: ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС 2013 онд Сургалтын төрийн сангийн 2011, 2012 онуудын санхүүгийн үйл ажиллагаа, сургалтын зээлийн олголт, эргэн төлөлтийн байдалд шалгалт хийж: Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцан төгссөн оюутны дипломыг буцаан олгох ажлыг шуурхай зохион байгуулж, олгосон зээлийн үлдэгдэл 18.1 тэрбум төгрөгийг барагдуулах талаар улсын байцаагчийн албан шаардлага өгсөн байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ЕРӨНХИЙ ГАЗРААС

Тус сангийн 2016 оны тайланд аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна.

Мөн сангийн 2017 оны тайланд аудит хийж-150,211.3 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтын эргэн төлөгдөх зээл 37,292.2 сая төгрөг, дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын эргэн төлөгдөх зээл 13,610.3 сая төгрөг, буцалтгүй тусламжийн 4,837.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй учир дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол, Боловсролын зээлийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн **“Хязгаарлалттай”** санал дүгнэлт өгсөн байна.

Дөрөв.САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

"Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай" хуулийг 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хурал батлан гаргасан бөгөөд сан нь энэ хуулийн 6.1-д "Энэ хууль нь Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад болон гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа болон суралцаж төгссөн, Монгол Улсын иргэн, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах, дээд боловсролын сургалтын байгууллагыг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, дэмжих энэ ажлыг эрхлэх, зохицуулах, сурталчлах чиг үүрэг бүхий байгууллага, иргэнээс суралцагчид үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны нийтлэг зарчим, хэм хэмжээг тодорхойлно.", 9.3-т "Суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх байгууллага нь Боловсролын зээлийн сан байх бөгөөд суралцагчид төрөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг чанартай боловсролд сонгон хэрэглэх боломж нь нээлттэй байна" гэж заасныг бүрэн хэрэгжүүлжээ.

Боловсролын зээлийн сан нь 2016 онд төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 80 их, дээд сургуулийн 75666 суралцагчдад 89.3 тэрбум төгрөг, 2017 онд төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 78 их, дээд сургуулийн 19865 суралцагчдад 44.8 тэрбум төгрөгийн тэтгэлэг, сургалтын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийг олгожээ.

Боловсролын зээлийн сангаас 2016-2017 онд буцалтгүй тусламж, тэтгэлэг, зээлийн санхүүжилтэд олгосон хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал.

/сая төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2016 он						2017 он					
		Оюутны тоо		Төсөв	гүйцэтгэл	Зөрүү //+,./-//	Хувь	Оюутны тоо		Төсөв	гүйцэтгэл	Зөрүү //+,./-//	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл					Төлөвлөгөө	Гүйцэтгэл				
1	Мэргэжлийн боловсролын байгууллагад хөнгөлөлттэй зээлээр суралцагчид	6860	1830	1,000.0	568.3	431.7	56.8	0	0	-	-	-	-
2	Өндөр хөгжилтэй орны магистр, доктор-т суралцагчид	269	149	7,337.2	5,614.3	1,722.9	76.5	267	151	7,300.0	6,342.1	957.9	86.9
3	Дэлхийн шилдэг 100 их сургуульд суралцагчдад	265	238	17,600.0	16,880.9	719.1	95.9	250	195	14,500.0	14,362.1	137.9	99.0

4	Оюутны хөгжлийн зээл	35000	-	64,891.0	8,000.0	56,891.0	12.3	0	0	41,314.7	2,000.0	39,314.7	4.8
ЗЭЭЛИЙН ДҮН		42394	2217	90,828.2	31,063.5	59,764.7	34.2	517.0	346.0	63,114.7	22,704.2	40,410.5	36.0
5.1	Гадаадын бакалаврт суралцагчдад	42	13	1,500.0	1,449.9	50.1	96.7	3	3	500.0	201.4	298.6	40.28
5.2	ЗГ-ын гэрээгээр Монголоос гадаадад суралцагчдын тэтгэлэг	265	258	1,342.4	1,268.0	74.4	94.5	172	148	2,142.4	1,828.8	313.6	85.4
6	ЗГ-ын гэрээгээр Гадаадаас Монголд суралцагчдын тэтгэлэг	155	151	453.9	453.9	-	100.0	209	122	734.7	667.5	67.2	90.9
7	Дотоодын их, дээд сургуульд буцалтгүй тусламжаар суралцагчид /бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй /	6616	5415	6,991.3	6,991.3	-	100.0	6275	5839	12,796.8	12,796.8	-	100.0
8	Төрийн албан хаагчийн 1 хүүхдийн төлбөр	1825	533	203.4	203.4	-	100.0	314	268	306.5	276.0	30.5	90.0
9	Баруун 5 аймгийн замын зардал	15246	10239	1,085.9	1,085.9	-	100.0	10922	10918	1,033.4	1,033.4	-	100.0
10	Багш мэргэжлээр элсэгчдийн 650-751 ээс дээш оноотой суралцагчийн төлбөрийн зардал	1606	1513	1,000.0	1,000.0	-	100.0	1954	1517	4,835.8	4,835.8	-	100.0
11	Багшлах дадлагын зардалд	1000	461	535.0	535.0	-	100.0	710	704	327.1	327.1	-	100.0
12	Үндэсний тэтгэлэг	58000	54866	45,238.1	45,216.9	21.2	100.0			-	-	-	
Төрөөс иргэдэд олгох буцалтгүй тусламжийн дүн		84755	73449	58,350.0	58,204.3	145.7	99.8	20559	19519	22,676.7	21,966.8	709.9	96.9
13	БЗС-ийн үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн			238.4	223.6	14.8	93.8			328.50	325.5	3.0	99.1
НИЙТ ДҮН		127149	75666	149,416.6	89,491.4	59,925.2	59.9	21076	19865	86,119.9	44,996.5	41,123.4	52.2

Оюутны хөгжлийн зээлийн хувьд 2016 онд 56.9 тэрбум төгрөг, 2017 онд 39.3 тэрбум төгрөгийн зээл олгогдоогүй нь зээлийн хүү, барьцаа хөрөнгийн асуудал, арилжааны банкны тавигдах шалгуур зэргээс шалтгаалсан байна.

2016 онд нийт зардлын 34.7 хувь буюу 31,063.5 сая төгрөг нь 2217 оюутанд олгосон хөнгөлөлттэй зээл, 65.0 хувь буюу 58,204.3 сая төгрөг нь 73449 оюутанд төрөөс олгосон буцалтгүй тусламж байна.

2017 онд нийт зардлын 50.5 хувь буюу 22,704.2 сая төгрөг нь 346 оюутанд олгосон хөнгөлөлттэй зээл, 48.8 хувь буюу 21,966.8 сая төгрөг нь 19519 оюутанд төрөөс олгосон буцалтгүй тусламж байна.

Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгосон зээл, түүний эргэн төлөлтийн талаар:

- **Мэргэжлийн боловсролын байгууллагад хөнгөлөлттэй зээлээр суралцагчид болон оюутны хөгжлийн зээлийн талаар:**

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын 2.1-д “Элсэлтийн ерөнхий шалгалтад 600 болон түүнээс дээш оноо авсан элсэгч, 2.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа дараахь суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгохоор заажээ. Үүнд:

- хагас өнчин суралцагч
- малчин өрхийн суралцагч
- өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь ҮСХ-оос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч
- гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч

Энэ хөтөлбөрт сургалтын төлбөрийн зээлд 2016 онд 1,000.0 сая төгрөг, төсөвлөснөөс 1830 суралцагчийн 568.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Нэг оюутанд мэргэжлээс хамаарч 350.0-620.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгожээ. Эргэн төлөлтийн хувьд 2016 онд 412 суралцагч 273.3 сая төгрөгийг 2017 онд 458 суралцагч 319.8 сая төгрөгийн зээлийг буцаан төлжээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар 21,533.4 сая төгрөгийн авлагатай байна. Энэ авлагын барьцаанд зээлээ төлөөгүй суралцагчдын диплом Боловсролын зээлийн санд хадгалагдаж байна.

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт болох “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын 2.1 дүгээр заалтын хүчингүй болж 111 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Оюутны хөгжлийн зээлийн журам” батласнаар 2017 оноос хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.

“Оюутан хөгжлийн зээл”-ийг арилжааны 6 банкинд /Голомт, Хаан, Төрийн, Хас, Капитрон, Улаанбаатар/ 2016 онд 8,000.0 сая төгрөг, 2017 онд 2,000.0 сая төгрөгийг байршуулсан байна. 2017 оны 10 дугаар сарын 25-нд Төрийн банкнаас 1,000.0 сая төгрөг, 11 дүгээр сарын 7-нд Хас банкнаас 500.0 сая төгрөг нийт 1,500.0 сая төгрөг Сангийн яамны улсын төсвийн 100900080001 тоот дансанд татан төвлөрүүлсэн байна.

Нийт 2353 суралцагчдад дээрхи банкуудаар дамжуулан 4,806.2 сая төгрөгийн зээлийг олгож 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,693.8 сая төгрөгийн эх үүсвэрийн үлдэгдэлтэй байна.

Олгосон дээрх нийт зээлээс эргэн төлөлт нь 29.1 хувь буюу 1,400.0 сая төгрөг байна. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ын 3.2 дугаар заалтын 3.2.3-т “Боловсролын зээлийн сан нь зээлийг 2 хувийн хүүтэйгээр банкинд олгох”, 3.3 дугаар заалтын 3.3.2-т “Банк оюутанд жилийн 5 хувийн хүүтэй зээл олгох эрх, үүрэгтэй” гэж заасны дагуу 10,000.0 сая төгрөгийн эх үүсвэрийн хүүг сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд 122.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны дансанд 34.1 сая төгрөг, нийт **156.3** сая төгрөгийн орлого орж, мөн хүүгийн авлага 2.5 сая төгрөг байна. 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Оюутны хөгжлийн зээл нь хүүгүй, барьцаагүй, банк оролцохгүй болж зөвхөн Боловсролын зээлийн сангаар дамжуулан олгогдохоор болсон байна.

Эргэн төлөгдөх зээлийн талаар.

Боловсролын зээлийн сангийн 2017 оны жилийн эцсийн тайланд эргэн төлөгдөх зээл нийтдээ 22,7 тэрбум төгрөг байгаа бөгөөд зээлийн ангилалаар авч үзвэл: Өндөр хөгжилтэй орны магистр, докторын хөтөлбөрөөр суралцагчдын зардалд 7.3 тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 151 суралцагчид 6.3 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Харин дэлхийн шилдэг 100 их сургуульд бакалаврын хөтөлбөрөөр 14.5 тэрбум төгрөг төсөвлөж батлагдсанаас 195 суралцагчдад 5.8 сая ам доллар буюу 14.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Энэ хөтөлбөрийн тухайд өнгөрсөн 2017 онд сонгон шалгаруулалт зарлаагүй бөгөөд үргэлжлэн суралцаж байгаа суралцагчдад олгосон санхүүжилт байна.

Оюутны хөгжлийн зээлийн хувьд тайлант онд 41.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 39.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сан 10 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд 85,120.0 сая төгрөгийг баталсан байна. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 45,311.9 сая төгрөг буюу 46.8 хувьтай байгаа нь дээр дурдсан 39.3 тэрбум төгрөгийн оюутны хөгжлийн зээл олгогдоогүйтэй холбоотой байна.

Зээлийн чөлөөлөлтийн талаар: 2017 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан 51 төгсөгчийн 1,376,814 ам.доллар буюу 3,341.7 сая төгрөгийн сургалтын зээлийг Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/88 дугаар тушаалаар чөлөөлсөн байна.

Өндөр хөгжилтэй оронд магистрантур, докторантурт суралцагчид:

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын 1.3-т “Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид зөвхөн сургалтын төлбөрийн, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоно.”, 3.2-т “Сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын зээлийг бакалаврт 2 жил, магистрантад 2 жил, докторантад 3 жил, докторын дараах сургалтад хамрагдагчид 1 жил хүртэлхи хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно.”, 3.3-т “Зээлд хамрагдах суралцагчийнг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн байна.

Дээрхи журамд заасны дагуу сургалтын болон амьжиргааны зардалд улсын төсвөөс 2016 онд 149 оюутанд 5,614.3 сая төгрөг, 2017 онд 151 оюутанд 6,342.1 сая төгрөгийг олгосон байна. Нийт суралцагчдаас 111 суралцагчийн 2,088.3 мянган ам долларын сургалтын төлбөрийн зээлийг дараах байдлаар чөлөөлжээ.

Тав: БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН 2016-2017 ОНУУДЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Боловсролын зээлийн сангийн 2016, 2017 онуудын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2016 он				2017 он			
	төлөв	гүйц	зөрүү	хувь	төлөв	гүйц	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	149,416,638.1	89,491,452.4	59,925,185.7	59.9	86,119,967.0	44,996,408.5	41,123,558.5	52.2
УРСГАЛ ЗАРДАЛ	58,588,438.1	58,427,949.3	160,488.8	99.7	23,005,283.7	22,292,253.3	713,030.4	96.9
БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,626.6	223,582.0	1,044.6	99.5	321,947.5	318,864.3	3,083.2	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	174,875.3	174,633.9	241.4	99.9	243,559.9	241,897.9	1,662.0	99.3
Үндсэн цалин	161,392.7	161,151.3	241.4	99.9	219,838.2	219,374.1	464.1	99.8
Нэмэгдэл					14,378.1	13,180.2	1,197.9	91.7
Унаа хоолны хөнгөлөлт	13,482.6	13,482.6	-	100.0	9,343.6	9,343.6	-	100.0
Урамшуулал								
Ажиллолгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,236.4	19,236.4	-	100.0	28,023.5	27,713.8	309.7	98.9
Тэтгэвэрийн даатгал	19,236.4	19,236.4	-	100.0	28,023.5	27,713.8	309.7	98.9
Тэтгэмжийн даатгал								
ҮОМШӨ-ний даатгал								
Ажилгүйдлийн даатгал								
Эрүүл мэндийн даатгал								
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14.2	-	14.2		-	-	-	-
Байрны түрээс	14.2	-	14.2					
Хангамж, бараа материалын зардал	17,007.2	16,979.4	27.8	99.8	22,720.8	22,720.8	-	100.0
Бичиг хэрэг	3,848.5	3,962.2	/113.6/	103.0	7,105.5	7,104.3	1.2	100.0
Тээвэр, шатахуун	3,645.8	3,888.5	/242.7/	106.7	6,222.2	6,222.2	-	100.0
Шуудан, холбоо интернэтийн төлбөр	7,357.4	7,045.1	312.3	95.8	7,916.3	8,267.8	/351.5/	104.4

Ном, хэвлэл								
Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	2,155.5	2,083.7	71.8	96.7	1,476.8	1,126.5	350.3	76.3
Эд хогшил, урсгал засварын зардал	1,643.2	882.5	760.7	53.7	2,373.7	2,373.7	0.7	100.0
Урсгал засвар	1,643.2	882.5	760.7	53.7	2,373.7	2,373.7	0.7	100.0
Томилолт, зочны зардал	2,500.3	2,500.3	-	100.0	1,336.3	470.1	866.2	35.2
Гадаад албан томилолт								
Дотоод албан томилолт	2,500.3	2,500.3	-	100.0	1,336.3	470.1	866.2	35.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,350.0	9,349.5	0.5	100.0	23,933.3	23,688.7	244.6	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,350.0	9,349.5	0.5	100.0	10,396.3	10,266.0	170.3	98.4
Мэдээллийн технологийн зардал					13,537.0	13,462.7	74.3	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,363,811.5	58,204,367.3	159,444.2	99.7	22,683,336.2	21,973,389.0	709,947.2	96.9
Ажил олгогчоос олгох бусад тэтг/ж, урамшуулал	203,412.0	203,412.0	-	100.0	306,480.0	275,966.0	30,514.0	90.0
Төрөөс иргэдэд олгох, тэтгэмж дэмжлэг	58,146,619.2	58,000,955.3	145,663.9	99.7	22,370,256.2	21,690,823.0	679,433.2	97.0
Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж	17,780.3	-	13,780.3	-	6,600.0	6,600.0	-	100.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	90,828,200.0	31,063,503.1	59,764,696.9	34.2	63,114,683.3	22,704,155.2	40,410,528.1	36.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,098,143.3	89,191,706.1	56,906,437.2	61.0	86,119,967.0	45,101,661.6	41,018,305.4	52.4
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	207,541.4	-	-	-	39,782.7	/ 39,782.7 /	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	39,782.7	-	-	-	103,631.2	/ 103,631.2 /	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100.0	22	22	-	100.0

Боловсролын зээлийн сан нь 2016 оны төсвийн жилд 149,416.6 сая төгрөгийн төсөв төсөвлөснөөс, гүйцэтгэлээр 89,491.5 сая төгрөгийг зарцуулж, 59,925.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж 59.9 хувийн зарлагын гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал зардалд 58,588.4 сая төгрөгийн төсөвтэй ажиллаж, гүйцэтгэлээр 58,428.0 сая төгрөг болж 160.5 сая төгрөгийн хэмнэлттэй, 99.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллажээ.

Бичиг хэргийн зардлыг батлагдсан хэмжээнээс 3.0 хувиар буюу 113.7 мянган төгрөгөөр, тээвэр, шатахууны зардлыг 6.7 хувиар буюу 242.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж, бусад 11 төрлийн зардлыг 53.7-100.0 хувийн гүйцэтгэлтэй, харин байр буюу ашиглалттай холбоотой тогтмол зардал /14.2 мянган төгрөг/, тэтгэвэрт гарахад нь олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж /13.8 сая төгрөг/-ийг зарцуулаагүй байна.

Нэмэлт санхүүжилтээр Боловсролын зээлийн сангийн 1009 0001 5432 тоот харилцах дансаар 2017 онд 162,427.3 мянган төгрөгийн /дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогоор 122,229.7 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлтийн орлогоор 40,197.6 мянган төгрөгийн эх үүсвэр буй болсон/, үүнээс багаж, хэрэгсэл худалдан авахад 10,208.0 мянган төгрөгийг, мэдээлэл технологийн үйлчилгээний /программ,

хангамжид/ зардалд 90,520.2 мянган төгрөгийг, зар суртчилгаа, мэдээллийн зардалд 4,230.0 мянган төгрөгийг, нийт 104,958.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 57,469.1 мянган төгрөгийг төсөвт эргэн төвлөрүүлжээ.

Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 2016 онд /4 төрлийн/ 90,828.2 сая төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр 31,063.5 сая төгрөг буюу 34.2 хувьтай байна.

2017 оны төсвийн жилд 86,119.9 сая төгрөгийн төсөв төсөвлөснөөс, 44,996.5 сая төгрөг зарцуулж, 41,123.4 сая төгрөгийн хэмнэлттэй буюу 52.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Урсгал зардлын хувьд 23,005.3 сая төгрөгийн төсөв батлагдаж 22,292.3 сая төгрөгийн зардал гарч, 713.0 сая төгрөгийн хэмнэлттэй, 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зардлын нэр төрлөөр авч үзэхэд: Шуудан холбоо, интернетийн төлбөрийн зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 4.4 хувиар буюу 351.5 мянган төгрөгөөр хэтэрч, бусад 14 нэр төрлийн зардлыг 35.2-100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэмнэлттэй буюу төлөвлөсөн хэмжээнд зарцуулж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл төлөвлөснөөр 63,114.7 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 22,704.2 сая төгрөг болж, 40,410.5 сая төгрөгийн хэмнэлттэй болж, 36.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ байдлаас үзэхэд шалгалтад хамрагдсан 2 жилд мэргэжлийн боловсролын сургуульд хөнгөлөлттэй зээлээр суралцагчдын, өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцагчдын, дэлхийн шилдэг 100 их сургуульд суралцагчдын болон оюутны хөгжлийн зээлд /санхүүжилт/-д олгосон гүйцэтгэл тухайн онуудад батлагдсан төсвийн гүйцэтгэл 34.2-36.0 хувь байгаагаас үзэхэд энэ үзүүлэлт ихээхэн доогуур байна.

Үндсэн хөрөнгийн талаар.

Боловсролын зээлийн сангийн захирлын 7/16 тоот тушаалаар томилогдсон 4 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс ажлын 4 өдөрт багтаан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дүгээр тушаалын хавсралтаар баталсан журмын дагуу үндсэн хөрөнгийн тооллогыг явуулжээ. Тооллогоор нийт 330,449.5 мянган төгрөгийн эд хөрөнгө тоологджээ. Үүнд:

1. Машин тоног төхөөрөмжийн бүртгэлд нийт 81 нэр төрлийн 126,385.3 мянган төгрөгийн,
2. Тавилга, эд хогшлын бүртгэлд 79 нэрийн 87,474.2 мянган төгрөгийн,

3. Тээврийн хэрэгслийн бүртгэлд, 49,800.0 мянган төгрөгийн 1 ширхэг суудлын автомашин,
4. Биет бус хөрөнгийн дансанд “Боловсролын зээлийн сангийн нэгдсэн программ хангамж” болох 66,790.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус тоолж баталгаажуулсан байна.

Тус сан нь 2016 оны төсвийн жилд 47,296.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 18,348.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил нийт 65,645.2 сая төгрөгийн хөрөнгөтэй байна.

Тус сан нь 2017 оны төсвийн жилийн эхэнд 139,619.4 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байсан бол 157,421.7 мянган төгрөг болж 17,802.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, үндсэн хөрөнгө оны эхэнд 109,712.1 мянган төгрөг байсан бол жилийн эцэст 137,432.5 мянган төгрөг болж 27,720.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант оны эхэнд нийтдээ 139,729.1 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол оны 157,559.1 сая төгрөгийн хөрөнгө тоологдож 17,830.0 мянган төгрөгөөр нэмэгджээ.

2017 оны эхэнд тээврийн хэрэгсэл анхны үнээр 49,800.0 мянган төгрөг, үлдэгдэл өртгөөр 14,885.4 мянган төгрөг, тоног төхөөрөмж анхны үнээр 99,014.4 мянган төгрөг, үлдэгдэл өртгөөр 25,456.8 мянган төгрөг, тавилга эд хогшил анхны үнээр 51,357.3 мянган төгрөг, үлдэгдэл өртгөөр 26,830.7 мянган төгрөг, биет бус хөрөнгө /программ хангамж/ анхны үнээр 140,320.2 мянган төгрөг, үлдэгдэл өртгөөр 70,259.6 мянган төгрөг, нийт анхны үнээр 340,491.9 сая төгрөгийн, үлдэгдэл үнээр 137,432.5 мянган төгрөгийн хөрөнгөтэй болжээ. Тайлангийн жилд 18,852.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 140.3 мянган төгрөгийн программ хангамжийг өөрийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэн, 4,676,577 төгрөгийн тавилга хэрэгслийг шилжүүлэн авч бүртгэжээ.

Мөн 46,223.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 40,793.5 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 66,790.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө нийт 3 төрлийн 149,622.2 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг тус тус акталж данснаас хасчээ. 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 1,441.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 0.6 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл нийт 2 төрлийн 1,501.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 274 тоот тогтоолоор БСШУСЯ-ны Боловсролын зээлийн сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон нийт 116,169,508.0 төгрөгийн балансын үнэтэй, 103,292,551.37 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсөн байна.

Боловсролын зээлийн сангийн авлага, өглөгийн талаар.

А. 2016 оны авлага, өр төлбөрийн талаар.

Тус сангийн 2016 оны санхүүгийн тайлангаас үзэхэд оны эхэнд 111.995.2 сая төгрөгийн авлагатай байсан бол жилийн эцэст 131,579.6 сая төгрөг болсон нь 19,584.4 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн байгаа нь өмнөх жилүүдээс хуримтлагдсан авлагатай байна.

Өр төлбөрийн хувьд тайлант оны эхэнд нийтдээ 1,579.5 төгрөгийн өглөгтэй байсан бол, 619.3 мянган төгрөгөөр буюу 39.2 хувиар бууруулж 960.2 мянган үлдэгдэлтэйгээр санхүүгийн тайлан гарсан байна. Нийт өглөгийн 95.9 хувь буюу 920.5 сая төгрөгийг албан байгууллагуудад 4.1 хувь нь буюу 39.8 сая төгрөгийг хувь хүмүүст өгөх өглөг тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын тайлант жилийн төсөв, түүний зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тодруулгыг 2016 оны гүйцэтгэлийн тайлбар хэсэгт зардлын ангилал тус бүрээр харуулжээ. Орлогыг орсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрсөн ба Төрийн сангийн харилцах дансанд байсан үлдэгдлийг буцаан төсөвт төвлөрүүлсэн ба мөнгөн хөрөнгийн хувьд Монгол банк дах валютын харилцах дансанд мөнгөн хөрөнгө 39,782.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайланд тусгажээ.

Тайлангийн жилд гадаадын их, дээд сургуульд суралцагчдын авлага 22.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба 2016 оны 06 сарын 23-ны өдрийн БСШУСайдын А/260 тоот тушаалаар 51 суралцагчийн 3.1 тэрбум төгрөг, дотоодын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн авлага олгосон төсвийн дагуу 568.0 сая төгрөгөөр нэмэгдэж, Сангийн яамны төсвийн орлогын 900000710 тоот дансанд 272.3 сая төгрөгийн сургалтын төлбөр эргэн төлөгдөж энэ хэмжээгээр авлага буурсан боловч нийт дүнгээрээ өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны төсвийн жилд /богино хугацаат хөрөнгө оруулалтын хувьд/ Засгийн газрын 111 дүгээр тогтоолоор Оюутны хөгжлийн зээлд 8.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг банкинд шилжүүлсэн байх бөгөөд банк 8.0 тэрбум төгрөгийн Вексель бичиж өгч, үүнийг БХХО-д бүртгэжээ.

Тайлант 2016 онд Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хүрээнд 90,828.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, /оюутны тоо 5417/ 31,063.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 59,764.7 сая төгрөгийг зарцуулаагүй байна. Үүнээс дээр дурьдсан оюутны хөгжлийн зээлийн эх үүсвэрт /3200 оюутанд/ 64,891.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсан боловч, наймны нэг хүрэхгүй хэсэг буюу 8.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, 56,891.0 сая төгрөг нь зарцуулагдаагүй тул буцаан төвлөрүүлжээ.

Мөн гадаадад суралцагчдад олгох санхүүжилт байсан хэдий ч санхүүжилтийн эрхийг нээгээгүйгээс 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэлгүй төсвийн жил дууссан байна.

Тайлант хугацаанд өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд суралцагч нийт 387 хүнд 22.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хэмжээгээр авлага нэмэгдсэн бөгөөд 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн БСШУСайдын А/260 тоот тушаалаар 51 суралцагчийн 3.1 тэрбум төгрөгийг чөлөөлж, 8 суралцагч 63.8 сая төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна. Мөн дотоодын их, дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр нийт 1830 суралцагчид 568.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, дээрхи дүнгээр дотоодын авлага нэмэгдсэн боловч Сангийн яамны орлогын дансанд 411 суралцагчийн 273.3 сая төгрөгийн авлага төлөгджээ. Ийнхүү дээрх 3.4 тэрбум төгрөгийн авлага буурсан нь тайлант үеийн өмнөх оны үр дүнг бууруулж байна.

Б. 2017 оны авлага, өр төлбөрийн талаар.

Боловсролын зээлийн сангийн 2017 оны санхүүгийн тайлангаас үзэхэд: Оны эхэнд 131,579.6 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн бол, оны эцэст 150,211.3 сая төгрөгийн авлагатай болж 18,631.7 сая төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн байна. Тайлант онд оюутны хөгжлийн зээлд 2,553.3 мянган төгрөгийн зээлийн хүү тооцож авлагаар нэмж бүртгэгдсэнээс шалтгаалан авлага өсөхөд нөлөөлсөн байна. Өр төлбөрийн хувьд оны эхэнд 960,240.2 мянган төгрөгийн өглөгтэй байсан бол 960,208.1 мянган төгрөгөөр буюу 99.9 хувиар барагдуулж, 32.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй гарчээ.

Тус сангийн 2017 оны төсвийн жилд санхүүгийн тайланд эргэж төлөгдөх зээлийн ангилалаар тусгасан нийт 22.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсныг хөтөлбөр тус бүрийн ангилалаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Өндөр хөгжилтэй орны магистр, докторын хөтөлбөрөөр суралцагчдын зардалд тайлант онд 7.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 195 суралцагчийн 5.8 сая ам.доллар буюу 14.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Энэ хөтөлбөрийн хувьд тухайн онд сонгон шалгаруулалт зарлаагүй, нэмж элсүүлээгүй зөвхөн өмнөх оноос үргэлжлүүлэн суралцаж байгаа суралцагчдад олгосон сургалтын төлбөрийн зээлийн санхүүжилт байна.

Зургаа. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

Тус сангийн санхүү бүртгэлийн албанаас Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллүүдийг тогтоосон хугацаанд жил, улирал, сар, бүр бүрэн оруулж хэвшсэн, шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, зардлыг санхүүжүүлэх хуваарь, төсвийн гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нийлүүлэгчийн нэр

хаяг, төлсөн төлбөрийн хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайлан хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан зэргийг оруулсан байна.

Долоо. ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛЫН ТАЛААР:

1. Боловсролын зээлийн сан болон суралцагч, захиалагчийн хооронд байгуулж байгаа сургалтын зээлийн гэрээний талаар.

Суралцагчид, Боловсролын зээлийн сан, захиалагч талуудын хооронд байгуулсан гэрээ нь Монгол улсын Иргэний хуульд заасан гэрээнд тавигддаг үндсэн зарчмуудад нийцээгүй, эрх зүйн харилцааны наад захын шаардлагыг хангаагүй гэрээ хийгджээ.

Боловсролын зээлийн сан үүссэн цагаас хойш гэрээний загвар, агуулгад 3 удаа өөрчлөлт оруулсан боловч, дээрхи зөрчил арилаагүй, боловсронгуй болж сайжраагүй, гэрээгээр хүлээх талуудын үүрэг хариуцлага адил тэгш бус байна.

Тухайлбал: талуудын эрх, үүрэг, хариуцлагын адил тэгш байх зарчим алдагдсан, зөвхөн Боловсролын зээлийн сангийн хүлээх үүрэг, хариуцлага давамгайлсан, зээлдэгчийн шууд хүлээх үүрэг, хариуцлага багассан, захиалагчийн үүрэг, хариуцлагыг үгүйсгэсэн гэрээ байна.

Мөн Боловсролын зээлийн сан, суралцагчийн үүрэг, хариуцлагыг салгаж, зааглан ялгаж өгөөгүй байна. “Суралцагчийн хүлээх үүргийн 4.6.-д ...суралцагч энэхүү гэрээний 4.1 дэх заасан“... миний бие ...оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн захиалагчтай тохиролцсоны дагуу ... улсын ... их сургуульд ... мэргэжлээр амжилттай суралцаж төгсөж ирээд 5-аас доошгүй жил гэрээнд заасан газар ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн тохиолдолд суралцах хугацаандаа авсан сургалтын төлбөр, тэтгэлгийн болон замын зардалд авсан зээлийг гэрээний заалтыг зөрчсөн болохыг гээд ...”Сургалтын төрийн сан” захиалагч байгууллагаас тогтоосон өдрөөс хойш 3 жилийн дотор дор дурьдсан хуваариар төлж барагдуулна гэж заажээ. Хэрэв зээлийг хугацаанд нь төлөлгүй хугацаа хэтэрвэл тухайн үед мөрдөгдөж байгаа арилжааны банкны хүүгийн хэмжээгээр төлнө гээд хуваарь гаргахаар тусгажээ.

Үүнээс үзэхэд суралцагч үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар харицлага хүлээх, сургалтын төлбөр, тэтгэлэг, замын зардалд авсан зээлийг төлүүлэх ч юм шиг, Сургалтын төрийн сан захиалагчид төлөхөөр ч юм шиг, нөгөө талаас суралцагчтай байгуулсан гэрээнд, үүргийн гүйцэтгэл хангагдаагүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх, зээлийг ямар хэлбэрээр, хэдийд, хэрхэн яаж төлүүлэхийг нь тодорхой заагаагүй, Төрийн сан өмнөөс нь төлчихөөд дараа нь суралцагчтай тооцоо хийх ч юм шиг, утга санаа нь тодорхой бус суралцагчийн хүлээх үүргийг тодорхойлж байснаа, захиалагчаас тогтоосон хуваарийн дагуу Төрийн сан 3 жилийн дотор төлж

барагдуулна гэж заасан нь талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг ялгаж зааглаагүй байна. Үүргээ хэрэгжүүлээгүй суралцагч ямар хариуцлага хүлээх, хэдийд хэрхэн яаж төлбөрөө барагдуулахыг нь /шууд/ тодорхой зааж өгөөгүй байгааг анхаарч засах шаардлагатай байна.

2.Оюутны зээлийн талаар:

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт болох “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын 2.1 дүгээр заалтын хүчингүй болж 111 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Оюутны хөгжлийн зээлийн журам” батлагдсан байна. “Оюутан хөгжлийн зээл”-ийн эх үүсвэрийг 6 банкинд /Голомт, Хаан, Төрийн, Хас, Капитрон, Улаанбаатар/ 2016 онд 8,000.0 сая төгрөг, 2017 онд 2,000.0 сая төгрөгийг байршуулсан байна. 2017 оны 10 дугаар сарын 25-нд Төрийн банкнаас 1,000.0 сая төгрөг, 11 дүгээр сарын 7-нд Хас банкнаас 500.0 сая төгрөг нийт 1,500.0 сая төгрөг Сангийн яамны улсын төсвийн 100900080001 тоот дансан буцаан төвлөрүүлсэн байна. Нийт 2353 суралцагчдад дээрхи банкуудаар дамжуулан 4,806.2 сая төгрөгийн зээлийг олгож 2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр 3,693.8 сая төгрөгийн эх үүсвэрийн үлдэгдэлтэй байна. Банкнаас оюутнуудад 4,806.2 сая төгрөгийн зээл олгосоноос эргэн төлөлт нь 29.1 хувь буюу 1,400.0 сая төгрөг байна.

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ын 3.2 дугаар заалтын 3.2.3-т “Боловсролын зээлийн сан нь зээлийг 2 хувийн хүүтэйгээр банкинд олгох”, 3.3 дугаар заалтын 3.3.2-т “Банк оюутанд жилийн 5 хувийн хүүтэй зээл олгох эрх, үүрэгтэй” гэж заасан нь зээлдэгчид нэмэлт хүүгийн ачаалал үүсгэж, арилжааны банкиг төсвийн хөрөнгөөр дэмжсэн үйл ажиллагаа болсон байна.

Харин энэ асуудлыг зөв харж Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Оюутаны хөгжлийн зээл олгох журам”-д өөрчлөлт оруулж хүүгүй, барьцаагүй, арилжааны банкны оролцоогүй болгон өөрчилж, энэхүү зээлийг зөвхөн Боловсролын зээлийн сангаар дамжуулан олгохоор болсон нь оновчтой, зөв зүйтэй шийдвэр болжээ.

3. Эрх зүйн үндэслэлгүйгээр үүсгэсэн авлагын талаар:

Тус сангийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын 2015 оны “Зөрчил арилгуулах тухай” 2/62 албан шаардлаганд “Сургалтын төрийн сангийн 2004 оны үйл ажиллагаанд хийсэн Үндэсний аудитын газрын аудитаар өндөр хөгжилтэй оронд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлийн хүү тооцож 1.9 тэрбум

төгрөгийн зээлийн хүүгийн авлага бүртгэснээс жил бүрийн валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан 2014 оны санхүүгийн тайланд 13.7 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэлтэй байгаа тул авлаг үүссэн шалтгааныг тодорхой болгож анхан шатны баримтыг бүрдүүлэх, зээлийн хүүгийн авлагын тооцоолол болон валютын ханшийн зөрүүгээс үүссэн олз/гарзын тооцооллыг дахин хянаж баталгаажуулах” гэсэн шаардлага өгсөн байна.

“...2004 онд Үндэсний аудитын газраас Сургалтын төрийн санд хийсэн шалгалтаар дээр дурдсан хүчингүй болсон журмыг баримтлан зээлийн хүүгээс хүү тооцож барагдуулах шийдвэр гаргажээ.

Энэ авлага нь өнөөг хүртэл үргэлжилсээр нийт 13.7 тэрбум төгрөгийн авлагатай мэтээр тус байгууллагын дансанд бүртгэгджээ. Сургалтын төрийн сангийн санхүүгийн тайланд хүүгийн авлагаар бүртгэгдсэн, авлагыг зохиомол шинжтэй өсгөөд байгаа 13.7 тэрбум төгрөгийн асуудлыг судлан үзэж байгууллагын балансаас хасалт хийлгэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын зүгээс Үндэсний аудитын газарт хандаж байжээ.

Энэхүү авлага 12.8 тэрбум төгрөг болсон бөгөөд эрх зүйн зохицуулалт, үндэслэл муутайгаар үүсгэсэн авлага тул цаашид барагдуулах боломжгүй болсон байна.

4. Дотоод хяналтын талаар:

Боловсролын зээлийн сангийн ажилтнууд “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох тухай” Засгийн газрын 2014 оны 71, 2011 оны 102, 2016 оны 111 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг төрийн өмчийн болон төрийн өмчийн бус хэвшлийн нийт 14 сургуулийн 4468 суралцагчдын сургалтын төлбөр, замын зардлын санхүүгийн тооцоо, анхан шатны баримтад тус сангаас шалгалт хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгах, төлбөр тооцоог боловсронгуй болгох, зээлийн үйлчилгээг шуурхай болгон, хамрах хүрээг өргөжүүлэх талаар ажилласан байна.

Харин дотоод аудитын алба байхгүй, зөвхөн нэг ажилтан томилсон төдий байгаа нь төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшиж, дадлагажаагүй, туршлагагүй, аудит хийх эрхгүй зэргээс тодорхой ажил хийгээгүй байв.

ДҮГНЭЛТ:

“Боловсролын зээлийн сан” нь өөрийн зорилго чиглэл, хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж, сургалтын төлбөрийн зээлийн үйл ажиллагааг эрхлэх, зохицуулах чиг үүрэг бүхий хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна. Гадаад, дотоодын дээд

боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад үндэсний тэтгэлэг, буцалтгүй тусламж болон сургалтын төлбөрийн, амьжиргааны зардлын зээлд зориулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийг тус сангаас бүрэн олгож, түүнд тавих хяналт, барьцаа баталгаа зохих хэмжээгээр сайжирсан байна.

Тус сан нь хэдийгээр цөөхөн орон тоогоор ажиллаж байгаа хэдий ч дотоодын сургалтын байгууллагуудтай хийх төлбөр, тайлан тооцоог шуурхай хийж хэвшсэн байна. Боловсролын зээлийн сангаас өндөр хөгжилтэй оронд болон дотоодын сургалтын байгууллагад зээлээр сурч байгаа суралцагчдын зээлийн төлөлтөд тавих хяналт болон сургалтын төлбөрөө төлөлгүй дипломоо барьцаанд үлдээсэн суралцагчдын талаар тодорхой арга хэмжээ авч, асуудлыг ямар нэг байдлаар шийдвэрлүүлэх шаардлагатай болсон байна.

Тус сан нь сүүлийн жилүүдэд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 9.4-д “Төрөөс санхүүгийн дэмжлэг авсан суралцагчдын бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг **Сургалтын төрийн сан эрхэлнэ**” гэж заасны дагуу гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид суралцагчдад улсын төсвөөс буцалтгүй, зээлийн хэлбэрээр олгож байгаа санхүүжилтийн төлбөр, тооцоог шуурхай хийх зорилгоор боловсролын байгууллагад суралцагчдын талаар нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх шинэ программ хангамжийг нэвтрүүлэн, сайжруулахад голлон анхаарч ажилласан байна.

Нийт авлага 2016 онд өмнөх оноос 19.6 тэрбум төгрөгөөр буюу 17.5 хувиар, 2017 онд 18.6 тэрбум төгрөгөөр буюу 14.2 хувиар тус тус өссөн байна. Дотоодын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгосон зээлээс 2017 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 150.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР